МЭДЭЭ · 2021 оны 1-р сарын 18

ПРОКУРОР ӨӨРИЙН САНААЧИЛГААР 587.3 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ҮНИЙН ДҮН БҮХИЙ 618 ИРГЭНИЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦЖЭЭ



УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

Прокурорын байгууллагад 1 их наяд 272 тэрбум төгрөгийн нэхэмжлэлийн дүн бүхий 1796 хүсэлтийг төрийн байгууллагуудаас ирүүлж, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцоноос төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж 1605, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж 167, аль аль нь зөрчигдсөн гэж 24 хүсэлтийг хүлээн авсан байна.

Прокурор нь төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалж төр, нийтэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээг авна.

www.prokuror.mn

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР



- ✓ **ПРОКУРОР ӨӨРИЙН САНААЧИЛГААР 587.3 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ҮНИЙН ДҮН БҮХИЙ 618 ИРГЭНИЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН НЬ 5.1 ДАХИН ӨССӨН БАЙНА.**


  - Прокурор өөрийн санаачилгаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмнөх онд 102 удаа оролцсон бол энэ онд 618 удаа оролцож 5.1 дахин, прокурорын нэхэмжлэл 102 байснаас 311 болж 2 дахин өссөн байна.

www.prokuror.mn

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

✓ **Прокурор төр, нийтийн эрх ашгийг хамгаалах нийт 504 иргэний хэрэгт оролцож, 558.7 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр шийдвэрлүүлсэн байна.**

Прокурор цагаатгалын нөхөх олговор, түүнтэй холбоотой садан төрлийн холбоо тогтоолгох нэхэмжлэлтэй 932 иргэний хэрэгт төрийг төлөөлөн оролцож, шүүх 40.2 тэрбум төгрөгийг, мөрдөн шалгах ажиллагааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэлтэй 19 хэрэгт прокурор оролцож, шүүх 1.6 тэрбум төгрөгийг тус тус Засгийн газрын нөөц сангаас гаргуулж шийдвэрлэсэн.



Эрүүгийн хэргийн улмаас төр, нийтийн ашиг сонирхолд учирсан хохирлыг гаргуулах 60 хэрэгт 376.3 тэрбум төгрөгийн, зөрчлийн хэргийн улмаас төр, нийтийн ашиг сонирхолд учирсан хохирлыг гаргуулах 21 хэрэгт 12 сая төгрөгийг, бусад төрлийн иргэний 423 хэрэгт 182.4 тэрбум төгрөгийг, нийт 504 хэрэгт прокурор оролцож, 558.7 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр шийдвэрлүүлсэн байна.

www.prokuror.mn

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2761